

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР**

Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.  
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой.

1. Нийгэмшлийн үйл явцыг хүн судлалын шинжлэх ухааны үүднээс тодорхойлсон нь аль вэ? /1 оноо/
  - A. Нийгэмшил бол соёлыг нэг үеэс нөгөө үед дамжуулан өвлүүлэх үйл явц
  - B. Нийгэмшил нь бие хүний хөгжил төлөвшлийн үйл явцын нэг бүрэлдэхүүн хэсэг
  - C. Хувь хүнийг нийгмийн үүрэгт сургах үйл явц
  - D. Хувь хүнийг нийгмийн харилцаанд оролцоход сурах, сургах үйл явц
  - E. Хүн соёлд дасан зохицож нийгмийн бүрэн эрхт гишүүн болж төлөвших үйл явц
  
2. Нийгмийн гажуудлын төрлийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
  - A. Гэмт хэрэг      B. Архидалт      C. Биеэ үнэлэх      D. Амиа хорлох      E. Шоронд хоригдох
  
3. .... бол нийгмийн анги бүлэг, үндэстэн хоорондын болон тэдний дотоод дахь эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын амьдрал, үйл ажиллагааны олон талт хэлхээ холбоонуудын цогц юм. /1 оноо/
  - A. Нийгэм                      B. Нийгмийн харилцаа                      C. Иргэншил
  - D. Нийгмийн бүтэц              E. Иргэний нийгэм
  
4. Нийгэмшлийн гол хүчин зүйлсийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
  - A. Гэр бүл                      B. Сургууль                      C. Үе тэнгийнхэн
  - D. Сүм хийд                      E. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
  
5. Зөв харгалзуулна уу. /1 оноо/
  1. Полиандр                      а. Гэрлэсэн хосууд шинэ нутаг сонгож, эцэг эхээсээ тусгаар амьдардаг
  2. Патрилокаль                      б. Хүүхдийн биологийн эцэг нь тодорхойгүй байдаг гэр бүл
  3. Неолокаль                      в. Гэрлэсэн хосууд нөхрийн эцэг эхийн гэрт амьдардаг гэр бүл
  - A.1a2b3c                      B.1b2a3c                      C.1a2c3b                      D.1c2b3a                      E.1b2c3a
  
6. Бадрах Төв аймгийн арван жилийн сургуулиас ажлын гараагаа эхлээд сургалтын менежер, сургуулийн захирал, эрдмийн хүрээлэнгийн ерөнхийлөгч болтлоо дэвшжээ. Энэ нь нийгмийн шилжих хөдөлгөөний аль хэлбэрт хамаарах вэ? /3 оноо/
  - A. Үе хоорондын шилжих хөдөлгөөн                      B. Бүлгийн шилжих хөдөлгөөн
  - C. Үеийн доторхи шилжих хөдөлгөөн                      D. Олдмол байр суурь
  - E. Бүтцийн шилжих хөдөлгөөн
  
7. Нийгмийн хувьсгал хэмээх ойлголтын тодорхойлолт аль нь вэ? /1 оноо/
  - A. Өөрийн гэх нутаг дэвсгэрийн хязгаар, төр засаг бүхий хүмүүсийн бие даан оршин амьдарч буй онцлог нутаг
  - B. Засаглал удирдлагын тодорхой дэг журам бүхий тухайн улс орон, нийгмийг удирдах улс төрийн цөм байгууламж
  - C. Тодорхой улс орон ард түмний түүхэн хөгжлийн шатан дахь нийгэм улс төр эдийн засаг, соёлын тогтвортой хамтын ажиллагаа харилцан үйлчлэл, хэрэгцээ сонирхлын ялгаа зөрчилдөөн бүхий хүмүүсийн нэгдэл
  - D. Нийгмийн хуучин байгуулал шинэ байгуулалд эрс шилжилт хийж, чанарын үсрэлтэнд хүрэх үйл явц
  - E. Хүний амьдралын нөхцөл чанар дээшлэх гэх зэрэг томоохон хэмжээний эерэг үр дагаврууд
  
8. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээрээ ялгаатай, эрх зүйн хувьд баталгаажсан хаалттай давхраажилтын систем аль нь вэ? /1 оноо/
  - A. Боолчлол                      B. Каст                      C. Язгуур                      D. Анги                      E. Ажилчин анги

9. Тодорхой нэг хүний өвөрмөц авьяас чадвар, өөрт нь заяагдсан статус аль нь вэ? /1 оноо/  
A. Мастер статус                      B. Олдмол статус                      C. Төрөлх статус  
D. Нуугдмал статус                      E. Бие хүний статус
10. Нийгмийн халамжийн үйлчилгээ нь: -олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;-төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэсэн хоёр төрөлтөй. Дараах өгөгдлийн аль нь төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамаарах вэ? /2 оноо/  
A. Бие даан амьдрах чадваргүй ахмад настныг байрлуулан асрамжлах  
B. Бага орлоготой өрхүүд хамтран хүнсний ногоо тариалах  
C. Боловсрол эзэмшихэд нь туслах  
D. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх  
E. Хүнсний бүтээгдэхүүн авах эрхийн бичиг олгох
11. “Худал бүү ярь, хулгай бүү хий, хариуцлагатай бай, ахас ихэсээ хүндэл” гэх мэтээр биеэ авч явах ёсыг захирамжлан тогтоох нь ... юм. /3 оноо/  
A. Ёс суртахууны онцлог              B. Ёс суртахууны шинж                      C. Ёс суртахууны нөлөөлөл  
D. Ёс суртахууны шаардлага      E. Ёс суртахууны бэлгэ тэмдэг
12. Ёс суртахууны үнэлэмж баримжааллын үүрэг аль нь вэ? /2 оноо/  
A. Хувь хүний үйл ажиллагааг бусад хүмүүс, нийгмийн эрх ашигт нийцүүлэн чиглүүлж байдаг.  
B. Ёс суртахууныг өөриймшүүлснээр хүмүүс үйлдэл, үйл ажиллагаагаа хянаж удирдаж байдаг.  
C. Ёс суртахуунаар дамжин хүмүүс дүрэм, журам, үүргийнхээ талаар мэдлэг эзэмшдэг.  
D. Хүмүүс өөрийгөө авч явах чиг баримжаа эзэмшиж байдаг.  
E. Өөрийн болон бусдын ёс суртахууны төлөвшилд үнэлгээ өгч байдаг.
13. Соёл бүрийн зан үйлийн хэм хэмжээ, дүрмийг адилхан хүндэтгэдэг үзэл аль нь вэ? /1 оноо/  
A. Эерэг соёл                              B. Сөрөг соёл                              C. Релятивизм  
D. Этноцентризм                      E. Универсализм
14. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг тоочихдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /1 оноо/  
A. Бэлгэ тэмдэг      B. Хэл      C. Итгэл үнэмшил      D. Нийгэмшилт      E. Үнэлэмж
15. Соёлыг илрэх байдлаар нь хэрхэн ангилдаг вэ? /1 оноо/  
A. Соёлын динамик ба статик                      B. Соёлын олон янз байдал ба соёлын зөрчил  
C. Эдийн ба оюуны соёл                      D. Соёлын нэгдэл ба тархалт  
E. Ардын ба нийтийн соёл
16. Хамгийн энгийн дохио, тэмдгээс эхлэн байгалийн болон шинжлэх ухааны хэлбэржсэн хэл болох дохио тэмдгийн тогтолцоог судалдаг шинжлэх ухааныг ... гэнэ. /2оноо/  
A. Аксеологи      B. Антропологи      C. Социологи      D. Синергетик      E. Семиотик
17. Бид аливаа үйл явдал, үзэл санааг дэмжих, шүүмжлэх, магтах зэргээр янз бүрээр үнэлж дүгнэж байдаг. Энэ нь дараах ойлголтуудын алинд нь хамаарах вэ? /1 оноо/  
A. Үнэлгээ      B. Үнэлэмжийн баримжаа      C. Үнэлэмж      D. Үнэт зүйл      E. Үнэмшил
18. Соёлын гажилтыг хэрхэн тодорхойлдог вэ? /1 оноо/  
A. Нийгэм соёлын эрс өөрчлөлтүүд гарах үзэгдэл  
B. Нийгмийн тодорхой хэм хэмжээ үгүйн улмаас соёлын нэгдэл зөрчилдөх  
C. Орчин үеийн үйлдвэрлэлийн болон мэдээлэл технологийн хөгжлийн ачаар дэлхийн хүй амын хэрэглээ улам ижилсэж байна.  
D. Соёлд зүйл бүрийн хэм хэмжээ, үнэлэмж, ёс заншлууд бие биеэ дэмжиж, хоорондоо зохицох  
E. Соёлын зөрчилдөгч хэсгүүдийг нэгтгэж нийцтэй, нягтралтай бүхлийг бүтээх

19. Соёлыг философийн хандлагаар хэрхэн тодорхойлдог вэ? /2 оноо/  
 А. Соёлыг хүний мөн чанарын илэрхийлэл болох талаас нь тайлбарладаг.  
 В. Соёлыг аливаа нийгмийн аж төрөх ёс, нийгмийн зохион байгуулалтын хүчин зүйл гэж үздэг.  
 С. Янз бүрийн ард түмний домог, аман зохиол зэрэг соёлын уламжлалыг харьцуулж тайлбарладаг.  
 D. Соёлын утга санаа нь хүний гэх зүйлийг амьтны гэх зүйлээс ялгах хязгаар болж өгдөг хэмээн тайлбарладаг.  
 E. Соёл бол өв уламжлан авсан бүтээл, юмс, үзэл санаа, үнэт зүйл гэж тайлбарладаг.
20. Улс төрийн оролцоог эрх зүйн байршлаар нь ангилсан өгөгдөл аль вэ? /1 оноо/  
 А. Идэвхтэй ба идэвхгүй В. Хуулийн хүрээнд, хууль бус С. Нийцтэй ба нийцгүй  
 D. Сайн дурын ба албадлагын E. Ортодоксаль ба ортодоксаль бус
21. Ардчиллын үнэт зүйлсийг тоочихдоо илүүц зүйл дурдсан бол аль вэ? /1 оноо/  
 А. Тэгш эрх В. Иргэдийн оролцоо С. Сонгууль  
 D. Өмчийн олон хэлбэр E. Хуульд захирагдах ёс
22. Өгөгдлийг зөв харгалзуулсан хариултыг сонгоорой. /1 оноо/  
 1. Засаглалын хэмжигдэхүүн а. Хуулийн заалт  
 2. Засаглалын нөөц b. Цаг хугацаа  
 3. Засаглалын механизм c. Цэргийн тоо  
 A. 1a2b3c B. 1b2a3c C. 1c2b3a D. 1a2c3b E. 1b2c3a
23. Хоёр намын тогтолцоонд хамаарах ойлголтыг олно уу. /2 оноо/  
 А. Монгол улсад 1921-1990 он хүртэл тогтож байсан тогтолцоо.  
 В. ЗХУ болон социалист гэгдэж байсан орнуудад тогтож байсан тогтолцоо  
 С. Тухайн улс оронд засгийн эрх мэдлийг хүлээн авч хэрэгжүүлэх чадвартай хоёр нам давамгайлдаг.  
 D. Улс төрийн амьдралд хэд хэдэн нам идэвхтэй оролцдог.  
 E. Нэг нам дангаар ноёрхож, төрийн эрх мэдлийг барьдаг.
24. Улс төрийн системийн дотоод шаадлага аль вэ? /1 оноо/  
 А. Цалин, тэтгэвэр нэмэх В. Сангийн сайдыг огцруулах  
 С. Ноён ууланд уурхай байгуулахыг хориглох D. Сонгуульд оролцох  
 E. Хууль батлан гаргах
25. Ардчилсан сонгуулийн зарчимд хамаарахгүй өгөгдөл аль нь вэ? /1 оноо/  
 А. Бүх нийтээр оролцох зарчим В. Заавал саналаа өгөх зарчим  
 С. Тэгш оролцох зарчим D. Саналыг шууд өгөх зарчим  
 E. Саналаа нууцаар гаргах зарчим
26. ....төрийг дараах байдлаар ангилдаг. Үүнд: Ерөнхийлөгчийн засаглалтай, Парламентын засаглалтай, холимог засаглалтай зэрэг болно. /2 оноо/  
 А. Хаант төр В. Хэмжээгүй эрхт төр С. Бүгд найрамдах төр  
 D. Холимог төр E. Хэмжээт эрхт төр
27. Шууд ардчиллын сул талыг илэрхийлсэн өгөгдөл аль нь вэ? /2 оноо/  
 А. Нийгэмд улс төрийн тогтвортой байдал, дэг журмыг илүү хангадаг  
 В. Төрийн бодлого, шийдвэр боловсруулахад их хугацаа шаарддаг  
 С. Нийгмийн бүлэг, давхрааны хэт ялгарал, эсвэл тэгшитгэх байдлаас нийгмийг хамгаалдаг  
 D. Улс төрийн хариуцлагыг өндөржүүлдэг  
 E. Нийгэм улс төрийн тогтолцоог мэргэшиж, туршлагажсан хүмүүс удирдан зохион байгуулдаг.
28. Төрийн зүгээс нийгмийн амьдралд хамгийн бага оролцоотой дэглэм аль нь вэ? /1 оноо/  
 А. Консерватив В. Либераль С. Фашист D. Охлократ E. Коммунист

29. Эрх зүйт төрийн шинжид хамаарахгүй өгөгдлийг олно уу. /3 оноо/  
 А. Иргэд хуулийг заавал биелүүлэх ёстой.  
 В. Иргэн төр хоёр адилхан хариуцлага хүлээнэ.  
 С. Иргэдийн амьдралын наад захын баталгааг хуулиар тогтоох ёстой.  
 D. Төрөөс хүний эрхийг баталгаатай хангаж эдлүүлнэ.  
 E. Шүүгч зөвхөн хуульд захирагдана.
30. Үйлдвэрлэлийн хэмжээнээс үл хамааран гарч байдаг зардлыг.....гэнэ. /1 оноо/  
 А. Хувьсах зардал В. Тогтмол зардал С. Үйлчилгээний зардал  
 D. Шууд зардал E. Үйлдвэрлэлийн зардал
31. Нэг хүний эзэмшлийн аж ахуйн нэгжийн сул талыг илэрхийлсэн ойлголт аль нь вэ? /3 оноо/  
 А. Хөрөнгийн хэмжээ бага, үүсгэн байгуулахад хялбар  
 B. Засгийн газраас тавих хязгаарлалтууд бага  
 C. Зөвхөн авсан эрхийн дагуу ажил үйлчилгээ явуулах ёстой  
 D. Ашиг хуваагдахгүй  
 E. Хүч чадал сул тул банкнаас өгөх зээлийн хэмжээ бага
32. Менежментийн үүрэгт хамааралгүй өгөгдөл аль нь вэ? /1 оноо/  
 А. Төлөвлөлт В. Зохион байгуулалт С. Зар сурталчилгаа D. Идэвхжүүлэлт E. Хяналт
33. Хувь хүний хувьд маркетинг нь ямар ач холбогдолтой вэ? /2 оноо/  
 А. Хэрэглэгчийн зан төлөв эрэлтийг мэдрэх B. Зах зээлээ таньж мэдэх  
 C. Өрсөлдөгчөө таньж мэдэх D. Ашиг орлогоо нэмэгдүүлэх  
 E. Зах зээлийн талаар илүү их мэдээлэлтэй болох
34. Зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. /2 оноо/  
 1. Валютын ханш а. Доллараар илэрхийлсэн төгрөгийн үнэ  
 2. Долларын ханш b. Төгрөгөөр илэрхийлсэн долларын үнэ  
 3. Төгрөгийн ханш c. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ  
 A. 1a2b3c B. 1b2c3a C. 1c2b3a D. 1a2c3b E. 1b2a3c
35. Гадаад худалдааны протекционист бодлогыг аль нь тодорхойлж байна вэ? /1 оноо/  
 А. Бусад улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц  
 B. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого  
 C. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлого  
 D. Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалж дэмжихийн тулд импортын барааны татварыг нэмэх юмуу импортод хязгаарлалт тогтоох бодлого  
 E. Импортын татварыг бууруулж хязгаарлалтыг үгүй болгох бодлого
36. Зөв харгалзуулна уу. /1 оноо/  
 1. Хувьцаа А. Тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа зохих хүүтэйгээр эргүүлэн төлөхөө амлаж байгааг баталсан үнэт цаас  
 2. Бонд B. Үнэт цаас гаргах, бүртгүүлэх, арилжих, хадгалах, өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбогдсон харилцаа  
 3. Үнэт цаасны зах зээл C. Компанийн ашгийн тодорхой хэсгийг нь авах /хувьцааны ногдол ашиг/ эрхтэй гэдгийг батлах баримт  
 A. 1b2a3c B. 1a2c3b C. 1c2a3b D. 1a2b3c E. 1c2b3a
37. Хувьцааны сул тал аль нь вэ? /2 оноо/  
 А. Ногдол ашиг авах  
 B. Ханшийн зөрүүнээс ашиг олох  
 C. Инфляцид өртөхгүй  
 D. Компани дампуурах тохиолдолд ногдол ашиг авах боломжгүй болох  
 E. Хөрвөх чадвар сайтай, хүссэн үедээ худалдаж болно

38. Аль нь үйлдвэрлэлийн хүчин зүйлс вэ? /1 оноо/  
 А. Байгаль орчин, эдийн засаг, нийгмийн байдал  
 В. Наслалт, нялхсын эндэгдэл, бичиг үсэгт тайлагдалт  
 С. Чөлөөтэй хөрвөх чадвар, хязгаарлагдмал хөрвөх чадвар  
 D. Гаалийн татвар, хөнгөлөлт, хязгаарлалт  
 E. Газар, хөдөлмөр, капитал, ур чадвар
39. Хүмүүсийн эрх ба үүрэг, үйл хэрэг ба үнэлэмж, хөдөлмөр ба урамшуулал, шийтгэл ба зэмлэлийн хоорондын харилцааны зохист шаардлагыг .....гэнэ. /1 оноо/  
 А. Эрх В. Эрх чөлөө С. Шударга ёс D. Дэг журам E. Тэгш эрх
40. Зөв харгалзуулна уу. /1 оноо/  
 1. Дэг журам А. Хууль хуульчилсан актад хамаарагдах бүхий л нутаг дэвсгэр, субъектын хүрээнд эрх зүйн шаардлагыг дагаж мөрдөх, сахих  
 2. Гэмт хэргийн төрлүүд В. Хөнгөн, хүнд, хүндэвтэр, онц хүнд гэсэн төрөлтэй  
 3. Хууль ёс С. Нийгэм дэх хүмүүсийн биеэ зөв авч явах эмх цэгц, байр байдал  
 А. 1a2b3c B. 1c2b3a C. 1a2c3b D. 1b2c3a E. 1b2a3c
41. Төрийн бодлого боловсруулах, зөвлөгөө өгөх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлагаар хангах нь..... албаны чиг үүрэг юм. /1 оноо/  
 А. Төрийн үйлчилгээний алба В. Төрийн тусгай алба С. Төрийн захиргааны алба  
 D. Улс төрийн алба E. Төрийн хамгаалалтын алба
42. Өргөдөл, гомдол гаргагчийн эрхэнд хамаарахгүй өгөгдлийг олно уу. /2оноо/  
 А. Төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх  
 В. Өргөдөл гомдлыг холбогдох төрийн байгууллага албан тушаалтан хянан үзэж, хариу өгөх  
 С. Гаргасан өргөдөл гомдлынхоо хариуг авах, тайлбар нотлох баримт гаргах  
 D. Өргөдөл гомдлоосоо татгалзаж буцааж авах  
 E. Өгсөн хариуг зөвшөөрөөгүй тохиолдолд зохих дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах
43. Буруу хэмждэг жин ашиглан орлого олсон тохиолдолд ямар төрлийн шийтгэл ногдуулах вэ? /2оноо/  
 А. Торгох В. Тусгайлан олгосон эрхийг хасах  
 С. Хууль бусаар олсон орлого эд зүйлийг хураах D. Баривчлах  
 E. Сануулга өгөх
44. Зөв харгалзуулна уу. /1оноо/  
 1. Пакт А. Ямарваа нэгэн асуудлаар улс орнуудыг тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг уриалсан олон улсын баримт бичиг  
 2. Тунхаглал В. Хүний эрхийн асуудлаар улс орнуудад үүрэг хүлээлгэдэг олон улсын эрх зүйн баримт бичгийн нэг төрөл  
 3. Конвенц С. Тодорхой асуудлыг хэлэлцэн тохирч баталсан олон улсын эрх зүйн баримт бичиг  
 А. 1b2a3c B. 1a2b3c C. 1b2c3a D. 1c2b3a E. 1a2c3b
45. Хүн бүр эрхээ эдлэх эрх зүй, эдийн засаг, нийгмийн нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авах нь төрийн .....үүрэг юм. /1оноо/  
 А. Хүндэтгэх В. Албан тушаал ахиулах С. Хангах D. Хамгаалах E. Ахиц дэвшил гаргах
46. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах өгөгдлийг олно уу. /1оноо/  
 А. Хэргийг шийдвэрлэх, гэм буруу хохирлыг эцэслэн тогтоох  
 В. Хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлөх  
 С. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх, ял эдлүүлэх  
 D. Гэмт хэрэг зөрчлийг шалгах, нийгмийн дэг журмыг хангах  
 E. Эрүүгийн хэрэгт хяналт тавих, ял шийтгэлийг тодорхойлох

47. Хүүхдийн эрхийн зарчмуудад хамаарахгүй өгөгдлийг олно уу. /1оноо/  
 А. Алагчлахгүй байх В. Хүүхдийн ашиг сонирхлыг эрхэмлэх С. Ахиц дэвшил гаргах  
 D. Эрхийг нь бүрэн эдлүүлэх E. Үзэл бодолд нь хүндэтгэлтэй хандах
48. Тусгай албан тушаалтан аль нь вэ? /2оноо/  
 А. Монгол банкны ерөнхийлөгч В. Улсын харьяаны их дээд болон ЕБС-ийн багш нар  
 С. Бүх шатны засаг дарга нар D. Монгол Улсын их хурлын дарга, гишүүд  
 E. Сонгуулийн Ерөнхий Хорооны ажлын албаны албан тушаалтнууд
49. Улс орнууд харилцан холбоо тогтоож, хамтран ажиллаж, харилцан бие биедээ нөлөөлж байгаа түүхэн үйл явц нь ..... юм. /2оноо/  
 А. Олон улсын харилцаа судлал В. Олон улсын харилцаа  
 С. Энх тайвнаар зэрэгцэн орших зарчим D. Дипломат харилцаа  
 E. Олон улсын хуулийн зохицуулалт
50. Аль нь НҮБ-ын албан ёсны хэл биш вэ? /1 оноо/  
 А. Франц В. Энэтхэг С. Англи D. Араб E. Хятад
51. Идэвхтэй гадаад бодлогын зарчим гэдэг нь: /1оноо/  
 А. Аль болох олон улстай харилцах  
 В. Олон талт хамтын ажиллагааны нөөц бололцоог бүрэн дүүрэн дайчлах  
 С. Үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг сахин хамгаалах  
 D. Стратегийн зорилтыг шатлан хэрэгжүүлэх  
 E. Язгуур эрх ашгаа эрхэмлэн дээдлэх
52. Зөв харгалзуулна уу. /1 оноо/  
 1. Олон улсын эрх зүй А. Улс орнууд өөрсдийн нэн чухал эрх ашиг, сонирхлоо чухалчлахын зэрэгцээ бусдын эрх ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн дээр харилцан ойлголцож, асуудлыг хамтран шийдвэрлэх  
 2. Олон улсын эрх сүйн хэм хэмжээ В. Олон улсын харилцаанд оролцогч субъектүүдийн хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоо  
 3. Улс орнуудын хамтын ажиллагаа С. Олон улсын эрх зүйн субъектүүдийн заавал биелүүлэх шинж чанартай гэж хүлээн зөвшөөрсөн ёс журам  
 А. 1a2b3c В. 1b2a3c С. 1b2c3a D. 1c2b3a E. 1c2a3b
53. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортлосон байвал тухайн аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 3 жилийн хугацаатай чөлөөлж, дараагийн 3 жил 50 хувиар хөнгөлнө. Энэ нь олон улсын харилцааны аль хэлбэрт хамаарах баримт вэ? /2оноо/  
 А. Олон улсын технологийн харилцаа В. Олон улсын соёлын харилцаа  
 С. Олон улсын улс төрийн харилцаа D. Олон улсын эдийн засгийн харилцаа  
 E. Олон улсын хүмүүнлэгийн харилцаа
54. Аль нь олон улсын харилцааны субъект биш вэ? /1оноо/  
 А. Бүрэн эрхт улс В. Олон улсын байгууллага С. Актор  
 D. Тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж буй үндэстэн E. Аж ахуйн нэгж
55. Дипломат төлөөлөгчийн газар, түүний үүрэгт хамааралгүй өгөгдөл аль нь вэ? /2оноо/  
 А. Суугаа улсдаа томилогч улсаа төлөөлөх  
 В. Олон улсын эдийн засгаар хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд томилогч улс түүний иргэдийн эрх ашгийг хамгаалах  
 С. Гадаад бодлогын үзэл баримтлал боловсруулах  
 D. Суугаа орны нөхцөл байдлыг хуулиар зөвшөөрөгдсөн бүх аргаар судлан өөрийн засгийн газарт мэдээлэх  
 E. Суугаа улсын засгийн газартай хэлэлцээ хийх
56. Зүүн өмнөд Азийн эдийн засаг, нийгэм, соёлын салбарт хамтран ажиллах, энх тайван тогтвортой байдалд дөхөм үзүүлэх байгууллага аль нь вэ? /1оноо/  
 А. АСЕАН В. АСЕМ С. АПЕК D. АРФ E. ШХАБ

**ХОЁРДУГААР ХЭСЭГ**

- Санамж: 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож хариуг бөглөөрэй.  
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

## 2.1 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Олон улсын хөдөлмөрийн хуваарь	1	Экспортын орлого импортын зардлаас давах
b	Олон улсын худалдаа	2	Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд алдагдсан боломжийн өртөг хамгийн бага байх
c	Гадаад худалдааны тэнцэл	3	Улс орнууд үйлдвэрлэлийн тодорхой төрлөөр дагнан төрөлжих үйл явц
d	Гадаад худалдааны харьцангуй давуу тал	4	Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээ шилжих хөдөлгөөн
e	Гадаад худалдааны ашиг	5	Экспорт, импортын зөрүү

## 2.2. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Сонирхлын артикуляци	1	Төрийн байгууллагад нөлөө үзүүлэх зорилготой.
b	Сонирхлын агригаци	2	Сайн дурын үндсэн дээр үүссэн байгууллага, хөдөлгөөн
c	Сонирхлын интеграци	3	Нийгмийн бүлгүүдийн сонирхлыг илрүүлэн гаргах
d	Сонирхлын бүлэг	4	Сонирхлыг улс төрийн шийдвэрт тусгуулах
e	Шахалтын бүлэг	5	Сонирхлыг нэгтгэн боловсруулах

## 2.3. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Нэг хэв загварын соёл	1	Дотооддоо онцлог ялгаа бүхий соёл бүрэлдэх, гадны соёлын элементүүд нэвтрэн шингэх боломжтой.
b	Олон хэв загварын соёл	2	Нэг ерөнхий итгэл үнэмшил, үнэт зүйлстэй, хаалттай
c	Соёлын түүхэн хэв маяг	3	Уран сайхны үнэ цэн арай багатай боловч хамгийн олон үзэгчтэй
d	Нийтийн соёл	4	Хүний дотоод ертөнц, үнэлэмжийн хөгжил, төлөвшлийн ялгаа
e	Соёлын түвшин	5	Хүй нэгдлийн, эртний, дундад зууны, сэргэн мандалтын г.м

## 2.4. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Нийгэмшлийн агент	1	Хүний амьдралын эхний шат / хүүхэд нас/-д тавигдаж, тухайн хүнтэй ойр дотны харилцаатай хүмүүс явуулдаг.
b	Анхдагч нийгэмшил	2	Нийгмээс тусгаарлагдаж, амьтдын дунд өссөн амьд бие юм. Жнь: Чонын үүрэнд өссөн Амала, Камала нар
c	Фераль хүн	3	Хайр халамжийн дутагдалд орж, нийгмийн дунд амьдрах чадваргүй болдог.
d	Деприваци	4	Хүүхэдтэй байнга ойр дотно харьцахгүй үед үүсдэг бөгөөд өвчлөл, нас баралт, оюуны хөгжлөөр үе тэнгийнхнээсээ хоцрох байдал илэрнэ.
e	Госпитализм	5	Хүний нийгэмшилд нөлөөлж байгаа байгууллага, бүлэг, бие хүмүүсийг хэлнэ.